

**БАТЛАВ:**  
**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**  
**..... БАРИУН-ЭРДЭНЭ**

**ЭРДЭНЭТ-БУЛГАН-ХӨВСГӨЛ ЧИГЛЭЛИЙН А1002 УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ  
ДАГУУ БУЛГАН АЙМГИЙН ХУТАГ-ӨНДӨР, БУГАТ СУМДЫН НУТАГТ ОРШИХ  
“ДОНДОГИЙН БУЛАГ” ОРЧМЫН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ  
ЗУРГИЙН ДААЛГАВАР**

2023.01.25

Дугаар. ЕТ 01/2023

Булган сум

		<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтооюур баталсан “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны Зорилт 4.2.2.Хөдөө аж ахуй, тээвэр логистик, төрөлжсөн аялал жуулчлалын салбарыг бүс, орон нутгийн хөгжлийг дэмжих замаар хөгжүүлнэ; 9.5.11.Хот, тосгоныг холбосон хурдны тойрог замын дагуу аялал жуулчлалын цогцолборуудыг байгуулж, Монгол брэндийн худалдааны төв нээн бизнес эрхлэгчдийг дэмжинэ.</li> <li>- Хот байгуулалтын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт;</li> <li>- Монгол Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтооюур баталсан “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын 4.7.2г, 4.7.3 4.7.5 б, 5.1.3 дахь заалтууд;</li> <li>- “Шинэ хөгжлийн зам”-Булган аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөр;</li> <li>- Аймгийн ИТХ-ын 2023 оны 02 сарын 20-ны өдрийн 14/01 дугаар тогтоол.</li> </ul>
		<p>Ерөнхий төлөвлөгөөг боловсруулахдаа дараах үе шатны дарааллаар хийнэ. Үүнд:</p> <p>а. Хот байгуулалтын суурь судалгаа /байр зүйн дэвсгэр зураг, инженер-геологийн судалгааг шаардлагатай хэсэгт өтгөрүүлэлт, судалгаа, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх. /Ажлын даалгаврыг гүйцэтгэгч нь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газартай заавал зөвшилцнө. /Нутаг, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтцийн судалгаа болон бусад судалгаа/-г 2023 оны байдлаар хийх;</p> <p>б. Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, Swot болон Pastle шинжилгээ;</p> <p>в. Төлөвлөлтийн үндсэн шийдэл, боловсруулалт;</p> <p>г. Ерөнхий төлөвлөгөөний дагуу хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө.</p>
		<p>Дондогийн булаг нь сүүлийн жилүүдэд Булган-Хөвсгөл чиглэлийн хатуу хучилттай улсын чанартай авто замын дэргэд замын хоолны газар ажиллуулах зорилгоор иргэд үүсгэн байгуулсан суурин юм. Дондогийн булаг нь Улаанбаатар хотоос 382 км, Эрдэнэт хотоос 104 км зайдай байршилд Хутаг-Өндөр, Бугат сумын нутгийн заагт Булган sumaas 50 км зайдай оршдог. Далайн түвшнээс</p>

		<p>дээш дунджаар 1300 метр өргөгдсөн, байгалийн эрс тэс уур амьсгалтай, физик газар зүйн хувьд Хангайн уулархаг мужид багтдаг. Газар хөдлөлийн эрчим 8 балл. Хуурай сэруүн цаг агаартай, зундаа сэруүвтэр, өвөлдөө цас их унадаг. зундаа +23 +31 хэм дулаарч, өвөлдөө -23 -34 хэм хүйтэрч цас их унадаг.</p> <p><b>Инженерийн дэд бүтэц.</b></p> <p><b>Зам:</b></p> <p>Булган Мөрөнгийн хатуу хучилттай авто замаар Улаанбаатар, Булган Эрдэнэт хоттой холбогдсон.</p> <p><b>Цахилгаан хангамж:</b></p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 35кВ-ийн ЦДАШ-аар 2022 онд холбогдсон.</p> <p><b>Усан хангамж:</b></p> <p>Суурингийн иргэд булгаас унд ахуйн усыг зөөврөөр хангадаг.</p> <p><b>Дулаан хангамж:</b></p> <p>Төвлөрсөн дулаан хангамжгүй.</p> <p>Өнөөдрийн байдлаар ариутгах татуургын шугам байхгүй.</p> <p><b>Орон сууц:</b></p> <p>Сууриннд инженерийн бүрэн хангамж бүхий орон сууц байхгүй. Айл өрхүүд өөрсдөө барьсан дүнзэн байшинд амьдардаг.</p> <p>Газар олголт төлөвлөлт сул.</p> <p>Суурингийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэтийн чиглэл:</p> <p>Суурингийн хөгжлийн төлөвлөгөөний хэтийн чиглэлийг Монгол улсын нийгэм эдийн засаг, бүс нутаг, хот байгуулалтын бодлоготой уялдуулан тодорхойлж түүнд тулгуурлан боловсруулах.</p>
4.	Төлөвлөлтийн хамрах хэмжээ (га):	Дондогийн булаг суурингийн ерөнхий төлөвлөгөөг Хутаг-Өндөр, Бугат сумдын хилийн заагийг хамран гүйцэтгэх бөгөөд үүнд: 126.6 га нь Хутаг-Өндөр сумын нутаг, 40.4 га нь Бугат сумын нутагт нийт 167.0 га талбайд төлөвлөнө. /Хавсралт-1/
5.	Баримт бичгийн бүрдэл	<p><b>Хот төлөвлөлтийн суурь судалгаа:</b></p> <p>“Хот байгуулалтын тухай” хуулийн 12.9 дэх хэсэг болон холбогдох хот төлөвлөлтийн норм, нормативын баримт бичгийн дагуу /инженер-геологи, байр зүйн зураглал, газар нутаг, хүн ам, нийгэм, эдийн засаг, байгаль орчин, дэд бүтцийн судалгаа болон бусад судалгааны тайлан г.м/ боловсруулна.</p> <p><b>Хөгжлийн ерөнхий төлөвлөгөө:</b></p> <p>Архитектур орон зайн төлөвлөлтийн зураглал:/M1:5000-25000/</p> <ul style="list-style-type: none"> <li>- Бүс нутгийн дэд бүтцийн сүлжээнд холбогдсон байдал, байршлын тойм зураг;</li> <li>- Хот байгуулалтын иж бүрэн үнэлгээний зураг ;</li> <li>- Ерөнхий төлөвлөгөөний үндсэн зураг;</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- Нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэлийн зураг;</li> <li>- Богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн зураг;</li> </ul> <p><b>Газар зохион байгуулалт: /M1:2000/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Газар зохион байгуулалт ;</li> <li>- Эхний ээлжийн төлөвлөлт ;</li> </ul> <p><b>Зам, тээврийн сүлжээ: /M1:2000/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гудамж, замын сүлжээ;</li> <li>- Нийтийн тээврийн сүлжээ;</li> <li>- Дугуйн замын сүлжээ;</li> <li>- Авто замын ус зайлцуулах сувгийн сүлжээ;</li> <li>- Авто замын тэнхлэгийн улаан шугамын төлөвлөлт;</li> </ul> <p><b>Инженерийн дэд бүтцийн хангамж: /M1:2000-5000/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Инженерийн хангамжийн эх үүсвэрүүд, шугам сүлжээний нэгдсэн төлөвлөлт</li> <li>- Инженерийн бэлтгэл арга хэмжээ, өндөржилт, улаан шугам;</li> <li>- Дулаан хангамж;</li> <li>- Цахилгаан хангамж;</li> <li>- Усан хангамж;</li> <li>- Ариутгах татуурга;</li> <li>- Холбоо мэдээлэл;</li> <li>- Сэргээгдэх эрчим хүч;</li> <li>- Хийн хангамж /شاардлагатай тохиолдолд/;</li> </ul> <p><b>Цэцэрлэгжилт, ногоон байгууламж:/M1:2000/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Цэцэрлэгт хүрээлэн, парк;</li> <li>- Тохижилт, ногоон байгууламж;</li> <li>- Гол, нуур, усан толио, цөөрмийн төлөвлөлт;</li> </ul> <p><b>Нийгмийн дэд бүтцийн хангамжийн төлөвлөлт /M1:2000/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Сургууль, цэцэрлэг, эмнэлэг, худалдаа, үйлчилгээ;</li> </ul> <p><b>Гамшгийн менежментийн төлөвлөлт /M1:2000/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Гал унтраах автомашиныг усаар цэнэглэх гадаргын ус хуримтлуулах нуур, цөөрөм, гудамж замын гидрант;</li> <li>- Түр хоргodoх байр, цуглах талбай, дуут дохио;</li> <li>- Нүүлгэн шилжүүлэх, авран хамгаалах;</li> </ul> <p><b>Аялал жуулчлалын менежмент: /M1:5000/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Дондогийн булаг орчмын аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө.</li> </ul> <p><b>Хог хаягдлын менежмент /M1:2000/</b></p> <p><b>Суурьшлын бүсийн дахин төлөвлөлт /M1:2000/</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Газар шинэчлэн зохион байгуулалт;</li> </ul> <p><b>Тайлбар бичиг:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ерөнхий төлөвлөгөө боловсруулсан үндэслэл, зорилго, хамрах хүрээ, бүрэлдэхүүн, аргачлал, арга зүй, ажлын төлөвлөгөө, хуваарь;</li> <li>- Хот байгуулалтын суурь судалгаа, дүгнэлт, хот байгуулалтын иж бүрэн үнэлгээ, харьцангуй давуу, сул талуудын харьцуулалт, хөгжилд нөлөөлөх хүчин зүйлүүдийн тодорхойлолт, эдийн засгийн тооцоо болон</li> </ul>
--	--

	<p>өмнөх ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтэд өгсөн үнэлэлт, дүгнэлт;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Орон зайн төлөвлөлтийн үндсэн шийдэл;</li> <li>- Богино, дунд, урт хугацаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө /төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг гаргах, ээлж дарааллыг төлөвлөлтийн үе шатны дагуу тогтоох, хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтийн тооцоог хийх г.м/;</li> <li>- Эхний ээлжинд хэрэгжүүлэх инженерийн болон нийгмийн дэд бүтцэд шаардагдах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг боловсруулах;</li> <li>- Техник-эдийн засгийн үндсэн үзүүлэлт;</li> <li>- Хүрээлэн буй орчин болон түүх, соёл, уран барилгын дурсгалыг хамгаалах, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө зэргийг нарийвчлан гаргаж, төлөвлөлтийн холбогдох зураг, зургийн даалгавар зэрэг материалыг хавсаргана.</li> <li>- Тайлбар бичиг, хөрөнгө оруулалтын тооцоо;</li> </ul> <p><b>Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд хэрэгжих томоохон төсөл, арга хэмжээний байршилын бүдүүвч зураг;</li> </ul> <p><b>Товч танилцуулга:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Хэвлэлийн эх бэлтгэл, цаасны формат /сонголтоор/;</li> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хураангуй;</li> <li>- Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хураангуй;</li> <li>- Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний онцлог давуу талыг тусгасан хурлын тараах материал;</li> <li>- Олон нийтэд зориулсан тараах материал /брошюр, анимэшн/;</li> </ul> <p><b>Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хот байгуулалтын нэгдсэн мэдээллийн санд хүлээж авахад тавигдах шаардлага:</b></p> <p><b>1. Бичиглэлийн баримт бичиг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Тайлбар бичиг /*.doc, *.pdf, *.xlsx / ;</li> <li>- Батлагдсан баримт бичиг скайнер /*.pdf, *.jpg/;</li> </ul> <p><b>2. Зураглалын баримт бичиг</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Ажлын файл /*.dwg, *.shp, *.skp, lumion, *.max, *.cdr/;</li> <li>- Батлагдсан баримт бичиг скайнер /*.jpg, *.pdf/;</li> </ul> <p><b>3. Товч танилцуулга</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Олон нийтийн хэлэлцүүлэг, хурлын танилцуулга /*.ppt/;</li> </ul> <p>Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эхлэлийн, дундын, эцсийн тайлангийн хугацаанд бичиглэлийн баримт бичгийг A4, зураглалын баримт бичгийг A1 форматаар 1% захиалагчид, улсын экспертизийн дүгнэлт гарч, эрх бүхий байгууллагаар батлагдсан хот байгуулалтын баримт бичгийг орон нутгийн архивд эх хувиар 1%, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын</p>
--	---

		<p>газарт тус бүр хуулбар 1% үйлдэж цаасан хэлбэрээр хүлээлгэн өгнө. Хот байгуулалтын баримт бичгийг тоон байдлаар DVD дээр бичиж хүлээлгэж өгөх: <b>Үнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>- Байр зүйн дэвсгэр зураг, инженер-геологийн судалгааны тайлан /*doc, зураглал *dwg/;</li> <li>- Ерөнхий төлөвлөгөөний файл /*dwg, *shp/;</li> <li>- Зураглалын материал /*jpeg/;</li> <li>- Тайлбар бичиг /*pdf, *word/;</li> <li>- Холбогдох хурлын тэмдэглэл, шийдвэр скайнердсан /*doc, *pdf/;</li> <li>- Зөвшөөрөлцөн байгууллагын шийдвэр скайнердсан /*pdf/;</li> <li>- Улсын экспертизийн дүгнэлт скайнердсан /*pdf/;</li> <li>- Батлагдсан шийдвэр скайнердсан /*pdf/ тус тус хуулж 3 хувь бэлтгэж Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, Аймгийн Засаг даргын тамгын газар, тухайн орон нутгийн аймгийн Архив, Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газарт тус бүр хүлээлгэж өгнө.</li> <li>- Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д нэвтрэх эрх авч баримт бичгийг төслийн шатанд оруулан холбогдох байгууллагаас цахимаар санал авах, батлагдсаны дараа эцсийн байдлаар хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний орон зайн мэдээллийг цахим системд оруулна.</li> </ul> <p><b>Тайлбар:</b> Ажлын зургийг гүйцэтгэхдээ “Хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд барилга байгууламж, тохижилт, нийгмийн болон инженерийн дэд бүтцийн өгөгдөл оруулах” журмыг баримтална.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Батлагдсан ажлын даалгаварт тусгагдсан иж бүрэн зураг</li> </ul> <p>төслийн эх хувь, тайлбар бичгийн хамт хэвлэмэл болон тоон байдлаар CD-нд 4 хувь үйлдэж Булган аймгийн архив, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Архив мэдээллийн төв, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, сумын ЗДТГ-т тус бүр хүлээлгэн өгөх.</p>
6.	Шийдвэрлэх үндсэн асуудлууд	<ul style="list-style-type: none"> <li>- Авто замын дагуух үйлчилгээний цогцолборыг төлөвлөх;</li> <li>- Шаардлага хангасан хүрэлцээт нийтийн бие засах газар төлөвлөх;</li> <li>- Зочид буудлын үйлчилгээ, дулаан зогсоол, шатахуун түгээх сүлжээ, хоолны газруудыг төлөвлөх;</li> <li>- Хүнсний болон орон нутгийн брэнд бүтээгдэхүүн бэлэг дурсгалын дэлгүүр тусгах;</li> <li>- Аялал жуулчлалын мэдээллийн төвийг байгуулах;</li> <li>- Таталцлын бус нутгийн аялал жуулчлалын маршрутыг гаргах;</li> <li>- Авто зогсоол, Бичил супермаркет, ATM, Кофе шоп, Үнэгүй интернет орчин, Бэлэг дурсгалтын дэлгүүр, Мотел, Машин засварын газар, Аялал жуулчлалын</li> </ul>

		<p>мэдээллийн төв , Шуудангийн үйлчилгээ, Худалдааны төв, Бичил музей зэргийг тусгах;</p> <ul style="list-style-type: none"> <li>- Тухайн орон нутгийн байгаль цаг уур, газар зүйн нөхцөл, нийгэм эдийн засгийн онцлогийг тусгасан барилгажилт, тохижилт бүхий орон зайн бүтэцтэй төлөвлөлтийн онцлог шийдлийг гаргах;</li> <li>- Ойр зэргэлдээ сумдын иргэдэд бараа бүтээгдэхүүн борлуулах, үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлэх;</li> <li>- Гэр хорооллын төлөвлөлт, замын сүлжээ, нийтийн үйлчилгээг боловсронгуй хүртээмжтэй болгох;</li> <li>- Байгалаын унаган төрхийг хадгалах, хамгаалах, түүний тэнцэл алдагдахаас сэргийлэх арга хэмжээг боловсруулах;</li> <li>- Аялагчид, жуулчдын маршрутыг гаргаж түр байрлах амралтын цэг, тав тухтай зорчих, амрах нөхцөлийг бүрдүүлсэн төлөвлөлтийг боловсруулан асуудал хариуцсан орон нутгийн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөх;</li> <li>- Дондогийн булаг орчмын төлөвлөлтийг боловсруулж, байгаль, орчныг хамгаалах цаашид авах арга хэмжээний саналыг дэвшүүлэх;</li> <li>- Шинээр төлөвлөлт хийх нутаг дэвсгэрт газар эзэмшиж, ашиглаж, өмчилж буй байдлын судалгаа хийж, байгууллага болон сумын иргэдээс төлөвлөлтөд тусгах зорилгоор санал асуулга, судалгаа явуулсан байх;</li> <li>- Ундны болон ахуйн хэрэгцээний усны асуудлыг нарийвчлан судлах, шийдлийг гаргах;</li> <li>- Инженер-геологийн нөхцөлөөс хамааруулан инженерийн бэлтгэл арга хэмжээ болон байгалийн аюултай үзэгдэл, гамшигаас урьдчилан сэргийлэх, хамгаалах зэрэг арга хэмжээг төлөвлөх буюу эрсдэл өндөртэй газарт цэцэрлэгт хүрээлэн, биеийн тамирын талбай зэрэг барилгажилт багатай бус төлөвлөх;</li> </ul>
7.	Баримт бичиг боловсруулах хугацаа	<p>Гэрээ байгуулснаас хойш 4 сар /120 хоног/  <b>Эхлэлийн тайлан:</b> /30 хоног/  -Одоогийн байдлын судалгаа, байр зүйн зураглал, одоогийн байдалд үнэлэлт дүгнэлт хийх, судалгааны түвшинд харьцуулсан хувилбар дэвшүүлж төлөвлөлтийн тооцоолол боловсруулах;  -Олон нийтээс санал авах /Төлөвлөлтийн хязгаарт хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас санал авах/  <b>Дундын тайлан:</b> /60 хоног/  -Эхлэлийн тайландаа өгсөн саналыг тусгаж төлөвлөлтийн үе шатанд тавигдах шаардлагын дагуу төлөвлөлтийг гүйцэтгэсэн байх;  -Төлөвлөлтийн шийдлийг олон нийтэд танилцуулж хэлэлцүүлэг хийх /Төлөвлөлтийн хязгаарт хамрагдаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, төр захиргааны байгууллагуудад танилцуулж хэлэлцүүлэг хийх/  -Инженер геологийн судалгааг дууссан байх.  <b>Эцсийн тайлан:</b> /30 хоног/  Ерөнхий төлөвлөгөөнд мэргэжлийн байгууллагаас өгсөн санал, дүгнэлтийг тусгаж эцсийн байдлаар хүлээлгэн өгөх.</p>

		Экспертизээр хянацаах хугацаанд энд тооцоогүй тул гэрээний тусгай нөхцөл заана.
8.	Баримт бичиг боловсруулахад шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	Хот, байгуулалтын хуулийн 15.1.2 дахь заалтын дагуу төслийг орон нутгийн төсвийн 46.0 сая төгрөгөөр санхүүжүүлнэ.
9.	Захиалагч байгууллага	Булган аймгийн Засаг Даргын Тамгын Газар, Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
10.	Гүйцэтгэгч байгууллага	Хот байгуулалтын баримт бичиг боловсруулах эрхийн зөвшөөрөлтэй Аж ахуй нэгж, байгууллагыг "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай" хуулийн дагуу сонгон шалгаруулж гүйцэтгүүлнэ;
11.	Зөвшөөрөлцөх байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>- Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аймгийн Ерөнхий архитектор болон Хутаг-Өндөр, Бугат сумын Засаг дарга, Засаг даргын Тамгын газартай зөвшөөрөлцөх;</li> <li>- Инженерийн дэд бүтцийн хангамжийг шийдвэрлэхдээ шугам сүлжээний газруудтай зөвшөөрөлцөх, урьдчилсан байдлаар санал авсан байх;</li> <li>- Хот байгуулалтын баримт бичигт экспертиз хийлгэж, нэгдсэн дүгнэлт гаргуулах.</li> <li>- Аймаг, сумын Засаг дарга;</li> <li>- Онцгой байдлын газар;</li> <li>- Орон нутгийн инженерийн хангамжийн хангаж байгууллагууд;</li> </ul>
12.	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> <li>- Ногоон хөгжлийн зарчмыг нэвтрүүлэн херс ус агаарын бохирдлыг бууруулах, усыг дахин ашиглах, гадаргын урсацыг хуримтлуулж ашиглах, гол мөрний урсгал усыг унд ахуйн зориулалтаар ашиглах, усны хэрэглээг багасгах боломжит хувилбаруудыг боловсруулах;</li> <li>- Төлөвлөлтийн шийдэл, нутаг дэвсгэрийн үүргийн бүсчлэл, газар зохион байгуулалт, гэр хорооллын дахин төлөвлөлттэй холбогдолтой асуудлыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, аймгийн Ерөнхий архитектор, хотын нийгэм эдийн засгийн хөгжил, дэд бүтэц, байгаль орчин, хөрөнгө оруулалтын асуудлыг сумын Засаг даргын тамгын газартай зөвшилцөх;</li> <li>- Хот төлөвлөлт, газар зохион байгуулалтын уялдааг хангаж урьд үүссэн зөрчлийг арилгаж инженерийн шугам сүлжээг гэр хороололд байгуулах бэлтгэл арга хэмжээг төлөвлөх;</li> <li>- Зураг төсөлд тодорхой эшлэл авсан техникийн баримт бичгийг тодорхой заах, холбогдох тооцоо, судалгааг тайлбар бичигт нарийвчлан тусгах;</li> <li>- Ерөнхий төлөвлөгөөний зураглалыг "Хот байгуулалтын мэдээллийн сангийн таних тэмдэг" MNS 6736:2018 стандартыг баримтлан зураглаж, "Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем"-д эрх авч оруулах;</li> <li>- ЗТБХБСайдын 2012.06.13-ны №183 тоот тушаалаар батлагдсан "Ерөнхий төлөвлөгөөний төсөлд олон нийтээр хэлэлцүүлэх журам"-ын дагуу суманд</li> </ul>

		<p>хэлэлцүүлэг хийх /Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулах/, иргэд, байгууллагуудын саналыг төлөөлөгч томилон 7-с доошгүй хоног авах, төлөвлөлтийн санал авах.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Төлөвлөлтийн шийдлийг сумын болон аймгийн Засаг дарга, ИТХ, мэргэжлийн байгууллагатай зөвшилцэх;</li> <li>- Ерөнхий төлөвлөгөөг мөрдөх, хэрэгжүүлэх талаар орон нутгийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудад сургалт зохион байгуулах.</li> <li>- “Хот тосгоныг хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г “Хот байгуулалтын тухай хууль”-ийн 12.6, 12.7-р заалтуудыг үндэслэн сумын ЗДТГ-тай хамтран боловсруулж, ерөнхий төлөвлөгөөний хамт аймгийн ИТХ-аар батлуулна.</li> </ul>
--	--	--

**ЗӨВШӨӨРСӨН:**

БУЛГАН АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

Д.ЭРДЭНЭБАТ

ХУТАГ-ӨНДӨР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

К.ТҮМЭН-ӨЛЗИЙ

БУГАТ СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА

Ц.БААТАРЧУЛУУН

**ХЯНАСАН:**

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ХЭЛСТИЙН ДАРГА



Б.ОДБААТАР

БУЛГАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА  
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН БАРИЛГА  
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ХЭЛСТИЙН ДАРГА БӨГӨӨД  
АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР

Б.ГАНЗОРИГ

**БОЛОВСРУУЛСАН:**

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,  
ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ХЭЛСТИЙН МЭРГЭЖИЛТЭН



О.ЧИНБАЯР

БУЛГАН АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА  
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН  
БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН  
ХЭЛСТИЙН МЭРГЭЖИЛТЭН

Н.ГҮРЖАВ



ХУТАГ-ӨНДӨР, БУГАТ СҮМДҮН НУТАГТ ОРШИХ “ДОНДОГИЙН БУЛАГ” СУУРИНГИЙН  
ХӨГЖЛИЙН ЕРӨНХИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ТАЛБАЙН БАЙРШИЛ 167 (га)

